



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/233

Булган

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалт, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэгжин ХХК /2008181/-ийн Булган сум 5 дугаар Хатанбаатар С.Магсаржавын 2 дугаар гудамж 223 тоотод байршилтай 6308005502 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 4456 м<sup>2</sup> газраас 905 м<sup>2</sup> газрыг Н.Саранчимэг /ЧМ56011569/-т, 56 м<sup>2</sup> газрыг Ц.Мягмарсүрэн /Т370090209/-д, үлдсэн 3495 м<sup>2</sup> газрыг Цэцэгжин ХХК-д, иргэн Д.Батсайхан /ГЙ70050414/-ын Булган сум 6 дугаар баг Залуус 7 дугаар гудамж 710 тоотод байршилтай 6308007587 нэгж талбар бүхий амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 588 м<sup>2</sup> газрыг кадастрын зураглалаар 574 м<sup>2</sup> болгон өөрчилж, газар эзэмших эрхийг М.Үүрийнтуяа /РЙ86110905/-д тус тус шилжүүлсүгэй.

2. Цэцэгжин ХХК, иргэн Н.Саранчимэг, Ц.Мягмарсүрэн, М.Үүрийнтуяа нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээ олгон газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны Б/117 дугаар захирамжийн Д.Батсайхан, 2016 оны А/372 дугаар захирамжийн Цэцэгжин ХХК-тай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ